



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ БОЛОН
ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СБА-2026/05-16/ШТА-НА

Баруун-Урт 2026 он



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Болдбаатар

Утас: 70512127 Цахим хаяг: oyunboldg@audit.gov.mn

Аудитор Э.Алтансүх

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Аудитор Б.Ганцэцэг

Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДУУЛСАН БОЛОВЧ ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН ҮНЭЛГЭЭ БОЛОН САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРИЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	5
1.1. Сүхбаатар аймагт 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодлогын чиглэлтэй уялдсан байна.	5
1.2. Төсөл, арга хэмжээг бодлогын баримт бичигтэй нь уялдуулан төлөвлөсөн ч ТЭЗҮ, тоног төхөөрөмжийн өртгийг бүрэн үндэслээгүй, зарим төслийн санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилаагүй нь төлөвлөлтийн үндэслэл, хэрэгцээ шаардлагын үнэлгээг бууруулж байна.	7
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ ҮЕ ШАТ ХУГАЦААНЫ ДООД ШААРДЛАГЫГ ХАНГАЖ, ГОМДОЛ МАРГААН ГАРААГҮЙ БОЛОВЧ ТӨЛӨВЛӨЛТ, ТББ, ҮНЭЛГЭЭ БОЛОН ЦАХИМ СИСТЕМИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.	10
2.1. Тусгай зөвшөөрөл, худалдан авах ажиллагааны төрлийг буруу тусгасан, мөн тендерийн баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр шалгаруулсан байна.	10
2.2. Худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол, маргаан гараагүй ч цахим системийн хяналт-шинжилгээ, ашиглалт, сайжруулалтын чиг үүргийн хэрэгжилт сул байна.	15
БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУГАЦААНД НЬ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖИЛ ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖСЭН Ч ЧАНАРЫН ДОГОЛДОЛ, БАРИМТ БҮРДЭЛ, ӨМЧЛӨХ ЭРХИЙН ШИЛЖИЛТ БОЛОН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН АСУУДАЛ БҮРЭН ШИЙДВЭРЛЭГДЭЭГҮЙ БАЙНА.	16
3.1. Тайлант онд 4 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, батлагдсан санхүүжилтийн 69 хувийг авсан боловч зарим хөрөнгийн дүгнэлт, өмчлөх эрхийн шилжүүлэг бүрэн хийгдээгүй байна.	16
3.2. Барилга байгууламжийн техникийн хяналт ерөнхийдөө хэрэгжсэн боловч материал, хийцийн чанарын баталгаажуулалтын баримт бүрэн бус, ашиглалтад хүлээн авсан зарим төсөлд илэрсэн доголдлыг арилгуулах хяналт хангалтгүй байна.	19
3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглагдаж байгаа боловч данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна.	22
Холбогдох байгууллагын санал:	25
Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:	25
ДҮГНЭЛТ: 25	
ЗӨВЛӨМЖ: 26	

Товчилсон үгийн тайлбар

АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОНХОБТХ	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
МСҮТ	Мэргэжил сургалт үйлвэрлэлийн төв
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын их хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХББОС	Хот байгуулалт, барилга орон сууцжуулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ	8
Хүснэгт 2	Тендер сонгон шалгаруулалт	14
Хүснэгт 3		
Хүснэгт 4	Улсын комисс хүлээн авсан төсөл, арга хэмжээ	20
Хүснэгт 5	Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээ	

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоолын дагуу хийв.
Аудитын зорилт	Улсын болон орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг АИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ.
Аудитын хамарсан хүрээ	Улсын болон орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч нар, тэдгээрийн харьяа байгууллагууд болон ГХБХБГ, зураг төслийн компаниуд зэрэг холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Болдбаатар, аудитор Э.Алтансүх, Б.Ганцэцэг нар 2026 оны 02 сарын 12-ны өдрөөс 4 сарын 30-ний өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДУУЛСАН БОЛОВЧ ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН ҮНЭЛГЭЭ БОЛОН САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРИЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1. Сүхбаатар аймагт 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодлогын чиглэлтэй уялдсан байна.

1.1.1. Сүхбаатар аймагт 2025 онд төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилттой нийцсэн боловч төлөвлөлтийн уялдааг илүү тодорхой болгох шаардлагатай байна.

1.1.1. Сүхбаатар аймгийн Засаг даргаас 2025 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт 158,106.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл арга хэмжээг эрэмбэлэн үнэлж, цахим системээр төлөвлөн Сангийн яаманд хүргүүлсэн байна.

1.1.2. Сангийн яаманд хүргүүлсэн саналаас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар нийт 7,854.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тайлант онд 3,545.3 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжих 2 төсөл, арга хэмжээ батлагдсан байна. Үүнд:

- ❖ “Дарьганга зуслангийн орчин үеийн стандартад нийцүүлсэн амралт, аялал жуулчлалын цогцолборын шинэчлэл /Сүхбаатар, Дарьганга сум/”,
- ❖ “Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Сүхбаатар, Баруун-Урт сум/” төслийн худалдан авах эрх орон нутагт шилжээгүй байна.

1.1.3. Сүхбаатар аймгаас 2025 онд санал болгосон 23 төсөл, арга хэмжээний дийлэнх нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний боловсрол, эрүүл мэнд, авто зам, эрчим хүч, инженерийн дэд бүтэц, ус хангамж, соёл, аялал жуулчлалын чиглэлийн дэд заалтуудтай нийцэж байна.

1.1.4. Тухайлбал, сургууль, цэцэрлэгийн барилга нь боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн төвийн барилга нь иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний орчныг сайжруулах, авто зам, дулаан, шугам сүлжээний төслүүд нь орон нутгийн дэд бүтцийн хангамжийг дээшлүүлэхэд чиглэжээ.

1.1.5. Иймд нийт төсөл, арга хэмжээ нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан зорилтыг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

1.1.2. Тоног төхөөрөмжийн хэрэгцээг тодорхойлсон боловч нэгдсэн судалгаа, эрэмбэлэлтэд үндэслэн төлөвлөх ажиллагаа хангалтгүй байна.

1.1.2.1. Нэн тэргүүнд хэрэгцээ шаардлагатай тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө байгууллага, салбарын хэрэгцээ, одоо ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн хүрэлцээ, насжилт, хүчин чадал, ашиглалтын түвшинд үндэслэсэн нэгдсэн судалгаа, мэдээллийг бүрэн бүрдүүлээгүй байна.

1.1.2.2. Нийт 23 төслийн саналаас зөвхөн 2 нь тоног төхөөрөмжийн санал байгаа нь тоног төхөөрөмжийн хэрэгцээг нэгдсэн байдлаар тодорхойлж, эрэмбэлэн төлөвлөх ажил хангалтгүй хэрэгжсэнийг харуулж байна.

1.1.2.3. МСҮТ болон Аймгийн төв номын сангийн үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжийн санал хүргүүлсэн нь тодорхой хэрэгцээнд үндэслэсэн боловч хэрэгцээ шаардлагын нэгдсэн судалгаа, тэргүүлэх чиглэлийн эрэмбэ, сонгон төлөвлөсөн үндэслэл, хүлээгдэж буй үр дүнг баримтаар нотолсон байдал хангалтгүй байна.

1.1.3. Дараа онд хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээг төлөвлөж, баримт бичгийн бүрдлийг хангах нөхцөлийг тодорхой түвшинд бүрдүүлсэн байна.

1.3.1.1. БОНХОБТХэлтэс нь дараа онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах хүрээнд зураг төсөв боловсруулах ажлын зардлыг өмнөх оны төсөвт тусган батлуулж байгаа нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн урьдчилсан нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.3.1.2. Мөн Сангийн Яамны цахим системд санал хүргүүлэхдээ зураг төсвийн магадлал, газрын захирамж, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийг холбогдох цахим сангаас татан авч, PDF хэлбэрээр хавсаргах боломжтой болсон нь төсөл, арга хэмжээний баримт бичгийн бүрдлийг хангах, бэлтгэл ажлын чанарыг сайжруулахад чиглэсэн байна.

1.3.1.3. Дараа онд хэрэгжүүлэх төсөл эргэ хэмжээний бэлтгэл ажлыг хангахад чиглэсэн зураг төсөл боловсруулах, бусад төлөвлөлтийн шаардлагыг хангах ажлуудыг үе шаттай хэрэгжүүлдэг болсон байна.

1.1.4. Төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг журам, аргачлалын дагуу тодорхой хэмжээнд тооцож эрэмбэлсэн байна.

1.1.4.1. БОНХОБТХэлтэс нь төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, холбогдох заавар, журмын дагуу эрэмбэлэн төлөвлөх чиглэлээр тодорхой ажил хэрэгжүүлсэн байна.

1.1.4.2. Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, үйл ажиллагааны журам”-ын дагуу төсөл бүрийн хэрэгцээ шаардлага, ач холбогдол, зорилго, санхүү-эдийн засгийн болон зардал үр дүнгийн шинжилгээг системд оруулж, оноогоор үнэлэн эрэмбэлж байгаа нь төсөл, арга хэмжээг журамд нийцүүлэн төлөвлөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.1.4.3. Төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг журам, аргачлалын дагуу тооцож, системээр үнэлэн эрэмбэлсэн боловч үнэлгээний оноо, шинжилгээний үр дүн, эрэмбэлсэн дарааллыг шийдвэр гаргалтад ашигласан

үндэслэл бүрэн баримтжуулаагүй байна. Иймд төлөвлөлтийн нотолгоо, баримтжуулалтыг сайжруулах шаардлагатай.

1.2. Төсөл, арга хэмжээг бодлогын баримт бичигтэй нь уялдуулан төлөвлөсөн ч ТЭЗҮ, тоног төхөөрөмжийн өртгийг бүрэн үндэслээгүй, зарим төслийн санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилаагүй нь төлөвлөлтийн үндэслэл, хэрэгцээ шаардлагын үнэлгээг бууруулж байна.

1.2.1. Барилга байгууламжийн 21 төсөл, арга хэмжээний санал илгээснээс 20 төсөл нь магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байна.

1.2.1.1. Аймгийн БОНХОБТХ-ээс Сангийн яамны цахим системд нийт 23 төсөл, арга хэмжээний санал илгээснээс 21 нь барилга байгууламжийн төсөл бөгөөд үүнээс 20 төсөл нь магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байна.

1.2.1.2. Олон нийтээс санал авах ажлыг жил бүрийн 4 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-ний хооронд “Улсын төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшнээр зохион байгуулж, аймгийн цахим хуудсаар сурталчилсан байна. Энэ нь төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө зураг төсвийн бэлтгэл хангалт болон олон нийтийн санал авах шаардлагыг тодорхой хэмжээнд хэрэгжүүлсэн байна.

1.2.1.3. Гэвч нийт барилга байгууламжийн 21 төслөөс 1 төсөл нь магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй байгаа бөгөөд газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийн бүрдэл бүрэн хангагдсан эсэх талаарх нотлох баримтыг төсөл тус бүрээр нягтлан баримтжуулах шаардлагатай байна.

1.2.1.4. Иймд магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй, олон нийтээр хэлэлцүүлсэн байх шаардлагыг ихэнх төсөл хангаж байгаа боловч газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл болон зураг төсвийн бүрдлийг бүх төсөлд бүрэн хангуулж төлөвлөх шаардлагатай байна.

1.2.2. ТЭЗҮ, тоног төхөөрөмжийн өртгийг ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, үнийн судалгаа, тооцоололд бүрэн үндэслэн төлөвлөсөн гэж үзэх боломжгүй байна.

1.2.2.1. Ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, харьцуулсан үнийн судалгаа, нэгж үнийн тооцоололд үндэслэн ТЭЗҮ, цахим систем, тоног төхөөрөмжийн өртгийг төлөвлөсөн байдал хангалтгүй байна. Учир нь төсөл, арга хэмжээний саналыг цахим системд илгээхэд ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зах зээлийн болон харьцуулсан үнийн судалгаа, өртгийн задаргаа тооцооллыг заавал хавсаргах шаардлага тавигдаагүйгээс эдгээр баримт материал бүрдэж хавсаргагдаагүй байна.

1.2.2.2. ТЭЗҮ, цахим систем, тоног төхөөрөмжийн өртгийг бодит хэрэгцээ, техникийн үзүүлэлт, зах зээлийн үнэ, нэгж өртгийн тооцоололд үндэслэн төлөвлөсөн гэж дүгнэх боломжгүй бөгөөд өртгийн үндэслэл, тооцооллын баримтжуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

1.2.3. Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байх зохицуулалт 3 төсөл арга хэмжээний хувьд хэрэгжээгүй байна.

1.2.3.1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан Соёл амралтын хүрээлэн /Сүхбаатар, Баруун-Урт сум/, “Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/”, “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөр, 1 дүгээр үе шат” гэсэн 3 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 2 багц төслийн хүрээнд 7 төсөл, арга хэмжээг ХББОС-ын сайдын багцын задаргаагаар Сүхбаатар аймагт хэрэгжүүлэхээр эрх шилжүүлж, хуваарилсан байна.

1.2.3.2. Эдгээр төсөл арга хэмжээнээс санхүүжилтийг нь хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилаагүй, 3 жилийн хугацаанд хэрэгжих дараах төсөл, арга хэмжээнүүд байна. Тодруулбал “Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний ажил”-ын нийт төсөвт өртгийн 24.8 хувь, “Сумын ундны усны эх үүсвэр, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн өргөтгөл шинэчлэлийн ажил”-ын 24.8 хувь, “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат” ажлын 22.2 хувийг тухайн жилд санхүүжүүлэхээр тусгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 (шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах)-д заасантай нийцэхгүй байна.

1.2.4. Зарим шилжих төсөл, арга хэмжээ 4–6 жил үргэлжлэхээр төлөвлөгдөж, санхүүжилт нь эхний жилүүдэд бага, сүүлийн жилд төвлөрсөн байдлаар батлагдсан нь төсөл хугацаандаа дуусахгүй байх, дараагийн төсвийн жилд санхүүжилтийн өндөр ачаалал үүсэх эрсдэлтэй байна.

1.2.4.1. Аймгийн хэмжээнд УТХО-аар санхүүжүүлэх 12 арга хэмжээ өмнөх оноос шилжин хэрэгжиж байна. Шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн байдлыг авч үзвэл зарим барилга угсралтын ажлыг 4-6 жилийн хугацаанд гүйцэтгэхээр төлөвлөж, батлуулсан байна.

Хүснэгт 1: Өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	
		Эхлэх	Дуусах		2024 он	2025 он
1	Соёлын төвийн барилга, 300 суудал /Сүхбаатар, Баяндэлгэр сум/	2021	2026	2,285.9	40.0	1,328.4
2	Соёл амралтын хүрээлэн /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2022	2025	7,732.6	4,513.2	2,219.3
3	Сургуулийн барилга, 320 суудал /Сүхбаатар, Түвшинширээ сум/	2024	2026	9,618.4	500.0	2,336.2

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

4	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Сүхбаатар, Уулбаян сум/	2024	2026	3,471.8	500.0	1,484.9
5	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Сүхбаатар, Баяндэлгэр сум/	2024	2025	3,473.8	37.2	2,030.2
6	Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м, гэрэлтүүлэг /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/	2024	2025	11,839.6	5,573.5	6,266.2
7	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2024	2025	4,271.1	3,956.8	314.3
8	Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Сүхбаатар, Асгат сум/	2024	2025	4,257.3	1,277.7	2,979.6
9	Уртын голын ногоон байгууламж /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2024	2025	9,506.4	2,000.0	7,506.4
10	Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Сүхбаатар, Асгат сум/	2024	2026	2,096.1	500.0	776.6
11	Соёлын төвийн барилга /Сүхбаатар, Онгон сум, 5 дугаар баг/	2024	2025	4,184.0	1,255.2	2,928.8
12	Дарьганга зуслангийн орчин үеийн стандартад нийцүүлсэн амралт, аялал жуулчлалын цогцолборын шинэчлэл /Сүхбаатар, Дарьганга сум/	2024	2025	3,739.1	1,869.6	1,869.6
Нийт дүн				66,476.1	22,023.2	32,040.5

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль

1.2.4.2. Тухайлбал: Баяндэлгэр суманд хэрэгжиж байгаа 2,285.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 300 хүний суудалтай соёлын төвийн барилгын ажил 2021-2026 онд, Баруун-Урт суманд хэрэгжиж байгаа 7,732.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Соёл амралтын хүрээлэнгийн барилга угсралтын ажил нь 3 багц болон үргэлжлэн хийгдэж байгаа учраас 2022-2025 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн байна.

1.2.4.3. Төсөл арга хэмжээний хэрэгжиж дуусах хугацаа, олгосон санхүүжилтэд дүн шинжилгээ хийж үзэхэд зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийг төлөвлөсөн хугацаанд олгоогүй, тэгш хэлбэрээр төлөвлөж хуваарилаагүйгээс дараагийн төсвийн жилд ачаалал үүсгэх нөхцөл байдал ажиглагдаж байна.

1.2.4.4. Тухайлбал: Түвшинширээ сумын 320 суудалтай 9,618.4 сая төгрөгийн өртөгтэй сургуулийн барилгын ажлыг 3 жилийн хугацаанд гүйцэтгэхээр төлөвлөж, батлуулсан боловч эхний 2 жилд 2,836.2 сая төгрөг буюу 29.4 хувийн санхүүжилт олгохоор баталсан байна. Уг төсөл арга хэмжээний хэрэгжих сүүлийн жилд төсвөөс

6,782.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор харагдаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.3.5, мөн төсвийн төсөлд тусгахдаа уг хуулийн шаардлагад нийцүүлж, жилийн санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх тухай Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын 3.3.3, 3.3.4.2 дахь зохицуулалттай нийцээгүй байна.

1.2.4.5. Санхүүжилтийг тэнцүү байхаар төлөвлөөгүй нь тухайн төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж дуусахгүй байх, төсөл арга хэмжээнээс иргэдийн хүртэх үр өгөөж хойшлох зэрэг сөрөг үр дагавартай байна.

1.2.5. Төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг цахим системд хэмжигдэхүйц байдлаар тодорхойлсон байна.

1.2.5.1. Цахим системд төсөл арга хэмжээ бүрээр хүрэх түвшний мэдээллийг текстэн байдлаар дэлгэрэнгүй танилцуулга оруулсан байна.

1.2.5.2. Энэ нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг суурь түвшин, зорилтот түвшин, хэмжих нэгж, хэрэгжүүлэх хугацаа, хамрах хүрээтэй уялдуулан тодорхойлж төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ ҮЕ ШАТ ХУГАЦААНЫ ДООД ШААРДЛАГЫГ ХАНГАЖ, ГОМДОЛ МАРГААН ГАРААГҮЙ БОЛОВЧ ТӨЛӨВЛӨЛТ, ТББ, ҮНЭЛГЭЭ БОЛОН ЦАХИМ СИСТЕМИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.

2.1. Тусгай зөвшөөрөл, худалдан авах ажиллагааны төрлийг буруу тусгасан, мөн тендерийн баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр шалгаруулсан байна.

2.1.1. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах хугацаанд эрх оройтож ирж буй байдал сөргөөр нөлөөлж байна.

2.1.1.1. Сүхбаатар аймагт 2025 онд УТХО-аар нийт 170,960.3 0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас 89,055.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээг эрх шилжүүлсэн байна. Үүнээс 2025 онд худалдан авах ажиллагааг зарлах 2 багцын 3 төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх тушаалыг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1 (Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна:) -д заасан хугацаанаас хойш эрх шилжүүлсэн байна.

2.1.1.2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг УИХ-аар 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталсан ба хуульд заасны дагуу 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/746 дугаар захирамжаар баталсан бөгөөд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2025 оны А/84, А/192, А/450 дугаар захирамжаар 3 удаа тодотгол хийсэн байна.

2.1.1.3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд УТХО-ын эх үүсвэрээр санхүүжих шинээр хэрэгжихээр эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээнээс Соёл амралтын хүрээлэн төсөл арга хэмжээний нэмэлт гэрээний 2,219.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг нээлттэй сонгон шалгаруулалтаар явуулахаар тусгасан, бусад 26,818.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл, арга хэмжээг тусгаагүй байна. Харин дээрх арга хэмжээнүүдийг худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан төлөвлөгөөнд оруулж олон нийтэд мэдээлсэн нь ил тод байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ боловч батлагдсан төлөвлөгөө, цахим систем дэх мэдээлэл хооронд зөрүү үүссэн байна. Энэ нь худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг батлагдсан төсөл, арга хэмжээ бүрээр бүрэн төлөвлөж, баталгаажуулах шаардлага бүрэн хангагдаагүйг харуулж байна.

2.1.1.4. Цаашид эрх шилжиж ирсэн болон төсөвт тодотгол, зохицуулалтаар нэмэгдсэн төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох шийдвэр гарснаас хойш хууль, журамд заасан хугацаанд нэмэлт өөрчлөлтөөр тусган баталж, цахим систем дэх мэдээлэлтэй бүрэн нийцүүлэн баталгаажуулж ажиллах шаардлагатай байна.

2.1.1.5. УТХО-аар 2025 онд хэрэгжихээр эрх шилжин ирсэн нийт 8 төсөл, арга хэмжээний хувьд эрх шилжиж ирсэн огнооноос хойш 20-иос дээш хоногийн дараа тендерийн үнэлгээний хороо байгуулах шийдвэр гаргасан байна. Хууль, журамд эрх шилжиж ирснээс хойш үнэлгээний хороо байгуулах тодорхой хоногийн хугацаа шууд тогтоогоогүй боловч үнэлгээний хороо нь тендер шалгаруулалтын баримт бичиг, зарлал, урилга боловсруулах, тендер хүлээн авах, нээх, хянан үзэх, үнэлэх чиг үүрэгтэй тул тендер зарлахаас өмнө бүрэн байгуулагдсан байх шаардлагатай. Гэвч цахим системийн төлөвлөлт хэсэгт үнэлгээний хороо байгуулахаар төлөвлөсөн хугацаа оруулаагүйгээс төлөвлөсөн болон бодит хугацааг харьцуулан дүгнэх боломжгүй байна.

2.1.1.6. Энэ нь тендер шалгаруулалтыг төлөвлөсөн хугацаанд зарлах, үнэлэх, гэрээ байгуулах ажиллагаа удаашрах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Цаашид эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааны бэлтгэл үе шат, үнэлгээний хороо байгуулах төлөвлөсөн болон бодит огноог цахим системд бүрэн оруулж, тендер зарлах, нээх, үнэлэх, гэрээ байгуулах хугацаатай уялдуулан хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

2.1.2. Техникийн тодорхойлолт болон түүний иж бүрдэл бусад баримт бичгүүдийг захиалагч худалдан авах ажиллагааны байгууллагад албан бичгээр хүргүүлж хэвшээгүй байна.

2.1.2.1. УТХО-аар хэрэгжих эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт болон техникийн тодорхойлолтын бүрэлдэхүүнд багтдаг бусад шаардлагатай баримт бичгүүдийг захиалагч буюу аймгийн ЗДТГ-ын БОНХОХБТХ-аас Сүхбаатар аймгийн Худалдан авах ажиллагааны газарт файл болон цаасаар хүргүүлжээ. Харин дээрх техникийн тодорхойлолт, ажлын зураг, төсөв, магадлалын дүгнэлт болон бусад шаардлагатай баримт бичгийг албан бичгээр хүргүүлээгүй нь “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих” журмын 2.2 дахь заалттай нийцэхгүй байна.

2.1.3. Зарим тендер шалгаруулалтын баримт бичигт тусгай зөвшөөрлийг буруу тусгасан зөрчил гарсан байна.

2.1.3.1. “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр”-ийн 1 дүгээр үе шатны багцад хамаарах “Баяндэлгэр сумын 8 айлын орон сууцны барилга”-ын ажлын зураг, төсвийн магадлалын дүгнэлтэд тус барилгыг төмөр бетон суурь, төмөр бетон каркас, нүхтэй хавтан хучилттай, 38 см тоосгон гадна ханатай, 12 см тоосгон дотор ханатай орон сууцны зориулалттай барилга байхаар тодорхойлсон байна. Үүнээс үзэхэд барилгын үндсэн хийц нь төмөр бетон арагт бүтээцэд хамаарч байгаа тул тендерийн баримт бичигт **БА-3.1 “арагт бүтээцийн”** тусгай зөвшөөрөл шаардахаар байхад **БА-2.1 “өрөгт бүтээцийн”** тусгай зөвшөөрлийг шаардсан байна. Харин архивласан буюу цаасаар хэвлэсэн тендер шалгаруулалтын баримт бичигт дээрх ТББ-т заасан БА-2.1-ийг БА-3.1 болгон залруулж хэвлэсэн байна. Энэ нь төсөл, арга хэмжээний ТББ-т заасан тусгай зөвшөөрөл нь барилгын хийц, технологийн онцлогт нийцээгүй байна.

2.1.3.2. Харин бусад төсөл, арга хэмжээний хувьд тендерийн баримт бичгийг боловсруулахдаа техникийн тодорхойлолт, зураг төсөв, ажлын тоо хэмжээ, технологийн онцлогтой уялдуулан оролцогчид тавих санхүүгийн чадавх, хүний нөөц, машин механизм, тусгай зөвшөөрөл болон техникийн чадавхын шаардлагыг төсөл, арга хэмжээний онцлог, цар хүрээнд нийцүүлэн тусгасан байна.

2.1.3.3. Түүнчлэн “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат” төсөл, арга хэмжээний багц 1 буюу 15 айлын орон сууц худалдан авах /Баруун-Урт сум/, багц 3 буюу 15 айлын орон сууц худалдан авах /Мөнххаан сум/ арга хэмжээг цахим системд зарлахдаа тендер шалгаруулалтын төрлийг “ажил” гэж сонгосон байна. Тухайн арга хэмжээний агуулга нь бэлэн орон сууц худалдан авах шинжтэй тул “бараа”-ны худалдан авалтад хамаарахаар байхад “ажил” гэж ангилсан нь яамны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ажил гэсэн төлөвтэй төлөвлөгдөж эрх шилжиж ирсэн тул тендерийн төрлийг өөрчлөх боломжгүй байдаг байна.

цахим системд нийтэлсэн мэдээлэл, тендерийн баримт бичгийн агуулга, худалдан авах ажиллагааны бодит шинжтэй нийцээгүй байна.

2.1.3.4. Дээрх нөхцөл байдал нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчим, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т заасан “бараа”-ны тодорхойлолттой тус тус нийцэхгүй байна. Мөн Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 1.3, 2.2.3-т заасан цахим системийг хууль, журам, аргачлалын дагуу хэрэглэх, тендер шалгаруулалтын зарлал, урилга, баримт бичгийг батлагдсан агуулгаар цахим системд нийтлэх шаардлагыг бүрэн хангагдаагүй байна.

2.1.4. Тендер зарласнаас нээх хүртэлх хугацаа хуулийн доод шаардлагыг хангаж байгаа боловч зарим төсөл, арга хэмжээний тендерийг эрх шилжсэнээс хойш 2–3 сарын дараа зарласан байна.

2.1.4.1. Тендер зарласнаас нээх хүртэлх хугацаа 21–29 хоног байгаа нь хуулиар тогтоосон доод хугацааг ерөнхийдөө хангаж байгаа боловч эрх шилжүүлсэн болон үнэлгээний хороо байгуулсан өдрөөс тендер зарлах хүртэл зарим төсөл, арга хэмжээнд хугацаа ихээхэн алдсан байна.

2.1.4.2. Тухайлбал, 2025.01.23-нд эрх шилжсэн зарим арга хэмжээнд тендерийг 2025.04.09–04.23-нд зарласан нь цахим системээр эрх шилжүүлэлтийг оройтуулсантай холбоотой байна.

2.1.4.3. Үүний улмаас төсөл, арга хэмжээний хэрэгжилт хойшлох, ажлын улирал алдах, гүйцэтгэл хойшилсноос санхүүжилтийн ашиглалт саарах, улмаар гэрээний хэрэгжилт шахагдаж үр дүн буурах эрсдэл үүсэж болзошгүй байна.

2.1.4.4. Иймд батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зарим төлөвлөгөөнд батлагдсан хугацааны шаардлагыг хангаж байгаа боловч цаашид батлагдсан төсөл, арга хэмжээ бүрээр эрх шилжүүлэлт, үнэлгээний хороо байгуулах, тендерийн баримт бичиг боловсруулах, зарлал нийтлэх үе шатыг нэгдсэн хугацааны графикаар хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

2.1.5. Тендерийн баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр шалгаруулсан байна.

2.1.5.1. Тайлант онд шинээр хэрэгжих 7, өмнөх оноос шилжиж ирсэн 1 төсөл арга хэмжээний нэмэлт ажилд сонгон шалгаруулалтыг tender.gov.mn цахим системээр явуулж, дараах хуулийн этгээдүүдийг гүйцэтгэгчээр шалгаруулсан байна.

Хүснэгт 2: Тендер сонгон шалгаруулалт

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Багцын задаргаа	Гүйцэтгэгч компани	Гэрээний дүн
1	Соёл амралтын хүрээлэн /Сүхбаатар, Баруун-Урт сум/		Их модун ХХК	2,216.2
2	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/	Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний ажил /Сүхбаатар, Баяндэлгэр сум/	Анусервис ХХК	17,587.5
		Сумын ундны усны эх үүсвэр, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн өргөтгөл шинэчлэлийн ажил /Сүхбаатар, Баруун-Урт сум/	Гом илч ХХК	1,648.3
3	Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат	Мөнххаан сум	Өдрийн аз ХХК	1,848.9
		Баяндэлгэр сум	Түвшинмөнх ХХК	988.0
		Наран сум	Түвшинмөнх ХХК	996.7
		Баруун-Урт сум	Амжилтгүй	-
		Онгон сум	Амжилтгүй	-

Эх сурвалж: Tender.gov.mn

2.1.5.2. Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд нийцүүлэн сонгон шалгаруулж гэрээг байгуулсан байна. Энэ нь тухайн төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хийж гүйцэтгэх чухал ач холбогдолтой юм.

2.1.5.3 Гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдийг хуульд заасан шаардлагыг хангасан эсэхэд нарийвчилсан горим хэрэгжүүлж, ирүүлсэн тендерийн баримт бичигт тулган баталгаажуулалт хийхэд дараах шаардлагыг хангаагүй тендерт оролцогч компанийг сонгон шалгаруулсан байна. Тодруулбал:

- Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат Баяндэлгэр сумын 8 айлын орон сууцны ТББ-т 2 м3 автомат зуурмаг зуурагч шаардсан байхад 1 м3 автомат зуурмаг зуурагч санал болгосон оролцогчийг шалгаруулсан.
- Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний ажил /Сүхбаатар, Баяндэлгэр сум/ төсөл, арга хэмжээний ТББ-т ижил төстэй ажлын ашиглалтад хүлээн авсан комиссын дүгнэлт ирүүлэх, дулааны инженер үндсэн ажилтан байх шаардлага тавьсан байхад шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендерт эдгээр баримт, материал дутуу байна.
- Сумын ундны усны эх үүсвэр, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн өргөтгөл шинэчлэлийн ажил /Сүхбаатар, Баруун-Урт сум/ төсөл, арга хэмжээний ТББ-т 18 тонны даацтай өөрөө буулгагч автомашин шаардсан

байхад шалгарсан компани 15 тоннын даацтай өөрөө буулгагчийн мэдээлэлтэй тендерт ирүүлсэн

2.1.5.4. Мөн төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат Баяндэлгэр сумын 8 айлын орон сууцны барилгын ажлын хяналтын зураг төсөв дэх ажлын тоо хэмжээтэй тендерт оролцогч компанийн ирүүлсэн төсөв дэх ажлын тоо хэмжээг тулган баталгаажуулахад ирүүлсэн төсөвт туссан ажлын тоо хэмжээний дийлэнх нь буюу газрын ажил, суурийн ажил, хана-хамар хана, хаалга-цонхны ажил бүрэн таарч байгаа боловч хучилтын ажил дээр бетоны марк зөрсөн, дээврийн ажил дээр “Дээврийн 15мм зузаан цементэн тэгшилгээ хийх-314.5 м2” ажил орхигдсон байна. Үүнийг Худалдан авах ажиллагааны газраас тодруулахад тендерт оролцогч Түвшинмөнх ХХК-ны 2025.05.22-ны өдрийн 36/25 тоот албан бичгээр дээрх дутуу орхигдсон ажлыг санал болгосон төсөвтөө багтаан батлагдсан зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэхээ илэрхийлсэн байна.

2.1.5.5. Иймд үнэлгээний шатанд тендерийн баримт бичигт заасан шаардлага болон ирүүлсэн нотлох баримтыг бүрэн тулган шалгаагүйгээс шаардлага хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан тул эдгээр тендерийг “шаардлага хангасан тендер” гэж дүгнэх боломжгүй байна.

2.2. Худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол, маргаан гараагүй ч цахим системийн хяналт-шинжилгээ, ашиглалт, сайжруулалтын чиг үүргийн хэрэгжилт сул байна.

2.2.1. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол гараагүй байна.

2.2.1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалттай холбоотойгоор, тендерт оролцогчоос Сангийн яаманд санал гомдол гараагүй.

2.2.2. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол гараагүй тул Сангийн яамны шийдвэрийн хэрэгжилт, холбогдох арга хэмжээний биелэлтийг үнэлэх нөхцөл үүсээгүй байна.

2.2.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалттай холбоотойгоор оролцогчоос Сангийн яаманд гомдол гаргаагүй тул Сангийн яамны хянан шийдвэрлэсэн шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх, түүнтэй холбоотой арга хэмжээний биелэлтийг шалгах нөхцөл үүсээгүй байна.

2.2.3. Цахим системийн ашиглалт, сайжруулалт, аюулгүй ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байгаа нь холбогдох журмаар тогтоосон чиг үүргийн хэрэгжилт сул байгааг харуулж байна.

2.2.3.1. Төрийн худалдан авах ажиллагааны газар нь “Худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөгөө, хууль тогтоомж, төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх” чиг үүргийг

хэрэгжүүлдэг боловч 2018 оноос хойш Сүхбаатар аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан тендер сонгон шалгаруулалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

2.2.3.2. Мөн Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага орон нутгийн нэгжүүдэд цахим системийн ашиглалт, сайжруулалтын талаар сургалт зохион байгуулах болон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэггүй байна. Энэ нь Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/248 дугаар тушаалын хавсралтаар баталсан Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журмын 3.2.8.(цахим системээр зохион байгуулж буй тендер шалгаруулалт, түүнд нийтлэгдэж буй мэдээлэлд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, хяналт тавих, илэрсэн алдаа, дутагдлыг арилгуулах тухай холбогдох байгууллагуудад шаардлага, мэдээлэл, зөвлөгөө хүргүүлэх) дахь үйл ажиллагаа болон 6.2.2.(цахим системийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор цахим системд байнгын хяналт тавих) дахь чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байна.

2.2.3.3. Мөн оролцогч цахим системээр тендер илгээхэд төлсөн үйлчилгээний хураамжийн 30 хүртэл хувийг цахим системийн найдвартай ажиллагаа, шинэчлэл сайжруулалт, аюулгүй байдлыг хангахад зарцуулах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

2.2.3.3. Иймд худалдан авах ажиллагааны цахим системд нийтлэгдэж буй мэдээлэл, орон нутгийн нэгжийн систем ашиглалт, тендер шалгаруулалтын явцад холбогдох байгууллагаас тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж цахим худалдан авах ажиллагааны ил тод, найдвартай байдлыг ханган ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУГАЦААНД НЬ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖИЛ ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖСЭН Ч ЧАНАРЫН ДОГОЛДОЛ, БАРИМТ БҮРДЭЛ, ӨМЧЛӨХ ЭРХИЙН ШИЛЖИЛТ БОЛОН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН АСУУДАЛ БҮРЭН ШИЙДВЭРЛЭГДЭЭГҮЙ БАЙНА.

3.1. Тайлант онд 4 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, батлагдсан санхүүжилтийн 69 хувийг авсан боловч зарим хөрөнгийн дүгнэлт, өмчлөх эрхийн шилжүүлэг бүрэн хийгдээгүй байна.

3.1.1. Тайлант онд 4 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, бусад төсөл, арга хэмжээнүүдийн дуусах хуульд заасан хугацаа болоогүй байна.

3.1.1.1. Тайлант онд Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Сүхбаатар, Асгат сум/, Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Сүхбаатар, Асгат сум/, Төрийн

албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр /Сүхбаатар, Мөнххаан сум/, Соёл амралтын хүрээлэн багц-1 /Сүхбаатар аймаг, Баруун-Урт/ төсөл, арга хэмжээ буюу нийт 4 төсөл, арга хэмжээ бүрэн дуусаж, хуулийн хугацаанд хэрэгжсэн байна. Харин бусад төсөл, арга хэмжээнүүдийн хувьд хуульд заасан дуусах хугацаа болоогүй байна.

3.1.2. Улсын төсөвт батлагдсан санхүүжилтийн 69 хувь буюу 27.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Сангийн яамнаас авч, гүйцэтгэлд олгосон байна.

3.1.2.1. Сүхбаатар аймгийн Засаг даргад 2025 онд эрх шилжин ирсэн 17 төсөл арга хэмжээний тухайн оны батлагдсан санхүүжилт 39,359.3 сая төгрөг, үүнээс 12 төсөл, арга хэмжээний 27,165.1 сая төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилт олгогдсон бөгөөд 5 төсөл, арга хэмжээний хувьд 2,733.2 сая төгрөгийн санхүүжилт ашиглагдаагүй байна. Дээрх санхүүжилт авсан 12 төсөл арга хэмжээний хувьд 5 төсөл, арга хэмжээний хувьд улсын төсөвт батлагдсан санхүүжилтийг бүрэн олгосон, 7 төсөл, арга хэмжээний хувьд 48.7-99.6 хувийн санхүүжилт авсан байна.

3.1.2.2. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат хүрээнд 15 айлын орон сууц худалдан авах (Мөнххаан сум), Сумын төвийн хатуу хучилттай авто зам (Сүхбаатар, Асгат сум), Соёл амралтын хүрээлэн (Сүхбаатар, Баруун-Урт сум) төсөл, арга хэмжээнүүдийн чанарын баталгаат хугацааны барьцаа 505.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.

3.1.3. Ашиглалтад хүлээн авсан 2 төсөл арга хэмжээний өөрчлөлтийн зураг, төсвийг гаргуулаагүй, гүйцэтгэлийг бодитоор хянаагүй байна.

3.1.3.1. “Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Сүхбаатар аймаг, Асгат сум/” төсөл, арга хэмжээний хүрээнд зуухны дулаан механикийн тохируулгатай хаалт, даралтын зөрүү тохируулагч, гадна дулааны шугамын зарим хэсэг, гадна тохижилтын 364 м² ажил зэрэг гүйцэтгэгдээгүй ажлыг төсвөөс хасаж тооцсон байна. Улсын комисс ажиллах үед нөөц эх үүсгүүр, нүүрсний конвейр, нүүрсний бутлуур зэрэг нэмэлт шаардлагатай асуудал яригдаж, комиссын шийдвэрт “ажлын зураг, төсөвт тусгагдаагүй бутлуур, конвейрын зөрүү болон үерийн усны хоолойн ажлыг магадалшгүй ажлын зардлаас санхүүжүүлэх”-ээр тусгасан байна. Гэвч дээрх нэмэлт болон өөрчлөлттэй холбоотой ажлын зураг төсөл боловсруулаагүй, төсөвт өөрчлөлтийг зохих журмаар баталгаажуулаагүй, бодит гүйцэтгэлийг баримтаар гаргуулж баталгаажуулаагүй байна.

3.1.3.2. Соёл амралтын хүрээлэн багц-1,2 /Сүхбаатар аймаг, Баруун-Урт/ төсөл, арга хэмжээний хувьд зарим ажлыг өөрчилж хийсэн тул өөрчлөгдсөн ажлууд дээр төсөв гаргах, “архитектор, захиалагч, зохиогч, захиалагчийн хяналттай ямар ч зөвшилцсөн зүйл байхгүй”, ажлын зураг төсөвт тусгасан хэмжээ, хийцээс өөрөөр, чанаргүй гүйцэтгэсэн талаар улсын комиссын хурлын тэмдэглэлд дурдагдсан байна. Мөн явган зам, парк, хүүхдийн тоглоомын цахилгааны утас ил гарсан, хагарсан, эвдэрсэн хэсэг, сандал, саравч, явган замын хашлага, гэрэлтүүлэг, ус

зайлуулах, ногоон байгууламж, хогийн сав, тоглоомын талбай, асфальтын зузаан зэрэг ажлыг засварлах, гүйцээх үүрэг даалгавар өгсөн байна.

3.1.3.3. Эндээс үзэхэд “Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Сүхбаатар, Асгат сум/” болон “Соёл амралтын хүрээлэн багц-1, 2 /Сүхбаатар аймаг, Баруун-Урт/” төсөл, арга хэмжээний хүрээнд ажлын зураг төсөвт тусгагдсан ажлыг бүрэн гүйцэтгээгүй, зарим ажлыг зураг төсөв, техникийн шийдэл, батлагдсан төсвөөс өөрчлөн гүйцэтгэсэн, өөрчлөгдсөн ажлын зураг төсөв, төсвийн тооцоог зохих журмын дагуу баталгаажуулаагүй, бодит гүйцэтгэлд үндэслэн хяналт хэрэгжүүлээгүй байна.

3.1.3.4. Иймд дээрх төсөл, арга хэмжээний өөрчлөгдсөн болон дутуу гүйцэтгэсэн ажлуудын бодит гүйцэтгэлийг газар дээр нь хэмжилт, тооцоо, холбогдох акт, фото зураг, техникийн баримтаар баталгаажуулж, ажлын зураг төслийг бодит гүйцэтгэлтэй нийцүүлэн шинэчлэн гаргуулж, өөрчлөлтийн төсвийг эрх бүхий этгээдээр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр гүйцэтгэлийн хяналтыг дахин хэрэгжүүлж, илүү олгосон буюу үндэслэлгүй санхүүжүүлсэн дүн байгаа эсэхийг тооцон холбогдох арга хэмжээ авч ажиллахыг шаардлагатай байна.

3.1.4. Мөнххаан сумын төрийн албан хаагчдын 15 айлын орон сууцны хувьд захиалагч болон ашиглагч байгууллагын дүгнэлт үйлдээгүй, өмчлөх эрхийн шилжүүлэг хийгдээгүй байна.

3.1.4.1. “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3.6.16.(гэрээ дүгнэсэн акт эх хувь), 4.3.6.18.(тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан акт), 4.7.9.(Төсөл, арга хэмжээний гэрээ дуусгавар болох, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад гэрээ дүгнэсэн актыг энэ журмын 16 дугаар хавсралтад заасан маягтын дагуу гаргах бөгөөд эцсийн санхүүжилтийн хүсэлтэд эх хувиар хавсаргана), 4.8.29.(Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх бөгөөд энэ журмын 16 дугаар хавсралтад заасан “Гэрээ дүгнэх маяг”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд эх хувиар хавсаргаж ирүүлнэ) дэх заалтуудын дагуу гэрээ дүгнэсэн акт, хүлээн авсан актуудыг үйлдэж, эцсийн санхүүжилтийг олгосон байна.

3.1.4.2. Харин “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат хүрээнд 15 айлын орон сууц худалдан авах (Мөнххаан сум)” төсөл арга хэмжээний хувьд чанар, стандарт нь ашиглалтын шаардлага хангаж байгаа талаар захиалагч болон ашиглагч байгууллагын дүгнэлтийг үйлдэлгүйгээр захиалагч эцсийн санхүүжилтийг олгосон байна. Энэ нь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3.7.11.(худалдан авч буй барилга байгууламж, дэд бүтцийн чанар, стандарт нь ашиглалтын шаардлага хангаж байгаа талаар захиалагч болон ашиглагч байгууллагын дүгнэлт эх хувь) дэх заалттай нийцэхгүй байна.

3.1.4.3. Мөнххаан сумын төрийн албан хаагчдын 15 айлын орон сууцыг худалдан авах төсөл, арга хэмжээний хувьд үл хөдлөх хөрөнгийн эрхийн шилжүүлэг улсын бүртгэлийн байгууллагад хийгдээгүй байхад “Орон сууц хүлээн авсан комиссын акт” үйлдэж, нийлүүлэгч “Өдрийн-Аз” ХХК-д 1,756.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Энэ нь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3.7.12.(үл хөдлөх хөрөнгийн болон газар эзэмших эрхийн гэрчилгээг захиалагч, эсхүл ашиглагч байгууллагын өмчлөлд шилжүүлсэн баримт бичиг) дахь заалтыг зөрчсөн байна.

3.2. Барилга байгууламжийн техникийн хяналт ерөнхийдөө хэрэгжсэн боловч материал, хийцийн чанарын баталгаажуулалтын баримт бүрэн бус, ашиглалтад хүлээн авсан зарим төсөлд илэрсэн доголдлыг арилгуулах хяналт хангалтгүй байна.

3.2.1. Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж, акт, фото зургаар баталгаажуулж байна.

3.2.1.1. Эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримтаас үзэхэд барилга байгууламжийн хэрэгжилтийн явцад зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн маягт, хяналтын гарын үсэг, тамга, зарим үе шатны акт, фото зураг, санхүүжилтийн хүсэлт, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулсан баримтуудыг бүрдүүлсэн байна. Тодруулбал барилга угсралт, авто зам, инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлуудад гүйцэтгэлийн явцыг хянаж, холбогдох мэргэжлийн байгууллага, захиалагч, гүйцэтгэгчийн төлөөллөөр баталгаажуулсан баримтууд хавсаргасан байна.

3.2.1.2. Гэсэн хэдий ч зарим төсөл, арга хэмжээний хувьд барилга байгууламжийн үе шат бүрээр хяналт хийсэн байдлыг далд ажлын акт, лабораторийн сорилт, геодезийн хэмжилт, фото зургийн тайлан, зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтын тэмдэглэлээр иж бүрэн, нэг мөр баталгаажуулсан байдал харилцан адилгүй байна. Иймд техникийн хяналт хэрэгжсэн боловч түүний баримтжуулалт, үе шат бүрийн нотлох баримтын бүрдэл, зураг төсөв болон бодит гүйцэтгэлийн тулгалтын баримтжуулалтыг цаашид сайжруулах шаардлагатай байна.

3.2.2. Барилга байгууламжийн бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандарт, заслын ажлын материалын шаардлагад тавих хяналтын баримтын бүрдэл дутуу хийгдэж байна.

3.2.2.1. “Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга (Асгат сум)” төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримтад бетон хийцийн далд ажлын акт болон бетон сорьцын лабораторийн шинжилгээний баримт хавсаргасан байна. Харин өрлөгийн ажлын стандарт болон заслын ажлын материалын шаардлагыг шалгаж баталгаажуулсан тусгай акт, сорилт, тохирлын гэрчилгээ, материал хүлээн авалтын

баримт хангалттай бүрдээгүй тул өрлөг, заслын ажлын чанарын хяналт бүрэн хэрэгжсэн гэж үзэх нотлох баримт хангалтгүй байна.

3.2.2.2. “Дарьганга зуслангийн орчин үеийн стандартад нийцүүлсэн амралт, аялал жуулчлалын цогцолборын шинэчлэл (Дарьганга сум)” төсөл, арга хэмжээний хувьд ажлын гүйцэтгэлийн баримтад элс, дайрганы лабораторийн сорилтын дүн, бетон нэмэлтийн бүтээгдэхүүний мэдээлэл, ажлын явцын фото зураг хавсаргасан байна. Гэвч бетоны бат бэхийг сорьц авч лабораторийн шахалтын туршилтаар баталгаажуулсан протокол, өрлөгийн ажлын стандартын хэмжилт, заслын материалын тохирлын гэрчилгээ, техникийн хяналтын чанарын акт хангалттай бүрдээгүй байна.

3.2.2.3. Эндээс үзэхэд захиалагч, техникийн хяналт хэрэгжүүлэгч барилга байгууламжийн бетон хийц, өрлөг, заслын ажлын чанар, материалын стандартын шаардлагад тавих хяналтыг баримтаар бүрэн баталгаажуулаагүй, чанарын хяналтын нотлох баримтын бүрдэл дутуу байна. Иймд цаашид захиалагч байгууллага нь барилга байгууламжийн бетон хийц, өрлөг, заслын ажил бүрийн чанарын хяналтыг бетон сорьцын лабораторийн шинжилгээний дүн, материалын тохирлын гэрчилгээ, материал хүлээн авалтын баримтаар иж бүрэн баталгаажуулж хэвших шаардлагатай байна.

3.2.3. Ашиглалтад хүлээн авсан 3 төсөл, арга хэмжээний дутуу хийгдсэн ажил болон чанарын асуудлыг арилгуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

3.2.3.1. Тайлант онд 4 төсөл, арга хэмжээ бүрэн дуусаж, улсын комисс ажиллан дүгнэлт үйлдэж, ашиглалтад хүлээн авсан байна. Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээнүүдийн талаарх мэдээллийг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 3: Улсын комисс хүлээн авсан төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Улсын комиссын актын дугаар
1	Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Сүхбаатар, Асгат сум/	2025.12.03 № СҮ-УТ2025/01
2	Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Сүхбаатар, Асгат сум/	2025.11.05 № 017/25
3	Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр /Сүхбаатар, Мөнххаан сум/	2025.06.16 № 01
4	Соёл амралтын хүрээлэн багц-1,2 /Сүхбаатар аймаг, Баруун-Урт/	2025.10.31 № СҮ-023/25 № СҮ-024/25

Эх сурвалж: БОНХОБТХ-ийн УТХО-р хэрэгжсэн төсөл, арга хэмжээний баримт

3.2.3.2. Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Сүхбаатар, Асгат сум/ төсөл, арга хэмжээний хувьд 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдөр цахилгааны трансформатор шатсан тул сумын нөөцөөс сольж байршуулан, хэвийн

ажиллагаанд оруулсан бөгөөд тус асуудлыг Асгат сумын ЗДТГ-аас гүйцэтгэгч “Гом-Илч” ХХК-д мэдэгдсэн байна.

3.2.3.3. Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Сүхбаатар, Асгат сум/ төсөл, арга хэмжээг “Алсын шар зам” ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд замын тэмдэг, тэмдэглэгээ, цагаан шугам, далан сэргээх, зарим газарт асфальт дэвсэх, ногоон байгууламж хийх, карьер нөхөн сэргээх зэрэг ажлууд дутуу, мөн гудамжны гэрэлтүүлгийн 86 ширхэг гэрэл асахгүй, гэмтэлтэй байгаа асуудлаар Асгат сумын ЗДТГ-аас гүйцэтгэгч компанид мэдэгдсэн байна.

3.2.3.4. Соёл амралтын хүрээлэн багц-1,2 /Сүхбаатар аймаг, Баруун-Урт/ төсөл, арга хэмжээний гадна тохижилт, ногоон байгууламж, усалгаа, гэрэлтүүлэг, камержуулалт, тоглоомын талбай, спорт талбай, бохир/цэвэр ус, хамгаалалт, тэмдэг тэмдэглэгээтэй холбоотой асуудлуудыг 2025 оны 09 сарын 18-ны өдрийн Улсын комиссын хурлын тэмдэглэлд дурдсан бөгөөд ногоон байгууламж, усалгаа гэх мэт ажлуудтай холбоотой үүрэг даалгаврын биелэлтийн зарим хуудсанд “биелсэн” гэж ерөнхийлөн бичсэн, зарим хуудсанд биелэлт багана хоосон, заримд нь үүрэг тус бүрээр биелэлтийг тодорхой тэмдэглээгүй байна. Иймд комиссын үүрэг даалгавар бүр бодитоор бүрэн хэрэгжсэн эсэхийг тухайн биелэлтийн хуудсаар дангаар нотлох боломж хангалтгүй байна.

3.2.3.5. Дээрх 3 төсөл, арга хэмжээний дутуу хийгдсэн ажлуудыг хийлгэх болон чанарын доголдлыг арилгуулах асуудлаар захиалагч болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд гэрээний ерөнхий нөхцөлд заасны дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах шаардлага үүссэн байна.

3.2.4. Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан байна.

3.2.4.1. Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг MNS 7023:2023 — “Улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага” стандартын дагуу байршуулахаар зохицуулсан байна.

3.2.4.2. Тодруулбал ажлын нэр, хөрөнгийн эх үүсвэр, хүчин чадал, захиалагч байгууллагын нэр, утасны дугаар, гүйцэтгэгч байгууллагын нэр, утасны дугаар, талбайн инженерийн нэр, утасны дугаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны нэр, утасны дугаар, гэрээний үнийн дүн, ажил эхлэх, дуусах хугацаа, төсөл хэрэгжиж бий болох 3D загвар зураг, бүтээн байгуулалтын загвар зураг зэрэг мэдээллийг тусгахаар заасан байна.



3.2.4.3. Мөн самбарын мэдээлэл Монгол хэл дээр бичигдэх бөгөөд самбарын дэвсгэр өнгө нь цэнхэр, үсгийн өнгө цагаан байхаар MNS 7023:2023-д заасан байна. Сүхбаатар аймагт эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээнүүдийн холбогдох мэдээллийг дээрх стандартад заасан шаардлагын дагуу бэлтгэж, байршуулж ажилласан байна.



3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглагдаж байгаа боловч данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

3.3.1. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглагдаж байгаа боловч өмчлөл, бүртгэлийн асуудал бүрэн шийдвэрлэгдээгүйгээс данс бүртгэлд бүрэн тусгагдаагүй байна.

3.3.1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн 3 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, улсын комиссоор хүлээн авсан байна.

3.3.1.2. Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон зарим хөрөнгө ашиглалтад орж, зориулалтын дагуу ашиглагдаж байгаа боловч холбогдох байгууллагын үндсэн хөрөнгийн данс бүртгэлд бүрэн тусгагдаагүй байна.

3.3.1.3. Аймгийн Орон нутгийн өмчийн газраас Мөнххаан суманд баригдсан 24 айлын орон сууцнаас худалдан авсан 15 айлын байр, Эрдэнэцагаан сумын 8 айлын

орон сууцны барилгыг орон нутгийн өмчид бүртгүүлэхээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хүсэлт хүргүүлсэн байна.

3.3.1.4. Харин Асгат суманд хэрэгжсэн “Сумын төвийн хатуу хучилттай авто зам”, “Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга” хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгүүлэхтэй холбоотой баримт материалыг Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн б, 2 дахь заалтад нийцүүлэн тухайн төслийг хэрэгжүүлсэн багцын төсвийн ерөнхийлөн захирагчийн шугамаар уламжлуулан шийдвэрлүүлэх талаар холбогдох хүсэлтийг хүргүүлээгүй байна.

3.3.1.5. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр гараагүйгээс ашиглагч байгууллага тухайн хөрөнгийг үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй байна.

3.3.1.6. Иймд хөрөнгө ашиглалтад орсон боловч бүртгэлд тусгах ажиллагаа эцэслэн шийдвэрлэгдээгүй нь хөрөнгийн эзэмшил, хадгалалт хамгаалалт, элэгдэл тооцоололт, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдалд нөлөөлөх эрсдэлтэй байна.

3.3.2. Төсөл, арга хэмжээ хэрэгжиж тодорхой үр дүн гарсан хэдий ч уг үр дүнг шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй харьцуулан тайлагнасан байдал хангалтгүй байна.

3.3.2.1. УТХО-аар өмнөх оноос дамжин хэрэгжсэн 4 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан байна. Дээрх төсөл, арга хэмжээнүүдийг 2025 онд ашиглалтад хүлээн авч, ашиглаж эхэлсэн нь хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд төлөвлөсөн ажлын хэрэгжилтийг хангаж, иргэдэд үзүүлэх үйлчилгээ, дэд бүтцийн нөхцөлийг сайжруулах бодит суурь болсон байна. Үүнд:

Хүснэгт 4: Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээ

№	Төсөл арга хэмжээ	Үр дүн / бодлогын үр дүн
1.	Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Асгат сум/	Иргэдийн зорчих нөхцөл сайжирч, зорчих хугацаа, зардал буурсан
2.	Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Асгат сум/	Дулаан хангамжийн найдвартай байдал сайжирч, хэрэглэгчдэд тогтвортой дулаан хүргэх нөхцөл бүрдсэн
3.	Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд 15 айлын орон сууц худалдан авах / Мөнххаан сум/	Төрийн албан хаагчдын тогтвор суурьшил сайжирч, хүний нөөцийн хангалт, нийгмийн баталгаа дээшилсэн.

Эх сурвалж: БОНХОБТХ-ийн УТХО-р хэрэгжсэн төсөл, арга хэмжээний баримт

3.3.2.2 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй харьцуулан тайлагнасан талаар нотлох баримт байхгүй тул холбогдох шаардлагын дагуу тайлагнасан гэж үзэх үндэслэлгүй байна.

3.3.2.3. Цаашид эдгээр төслийн үр дүн, үр нөлөөг бодлогын зорилтот түвшинтэй харьцуулан үнэлэх хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт, тайлагналын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

3.3.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бодлогын зорилтот үр дүнд хүрэх нөхцөл бүрдсэн байна.

3.3.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд Асгат сумын төвийн хатуу хучилттай авто зам, дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга, Мөнххаан суманд төрийн албан хаагчдын орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд 15 айлын орон сууц худалдан авах төсөл арга хэмжээнүүдийг ашиглалтад хүлээн авч хэвийн үйл ажиллагаа явуулж байна.

3.3.3.2. Эдгээр төслийн хүрээнд авто замын хүртээмж, дулаан хангамж, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулахад чиглэсэн бодлогын зорилтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.3.3.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг ашиглалтад хүлээн авч, ашиглаж эхэлснээр тухайн салбарын үйлчилгээ, хүртээмж, үйл ажиллагааны нөхцөлийг сайжруулсан тул бодлогын зорилтот үр дүнд тодорхой хэмжээнд хүрсэн байна. Гэвч үр дүнгийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд тулгуурласан үнэлгээ, тайлагнал дутмаг байгаа нь бүрэн хэмжээнд хүрсэн эсэхийг тогтооход хүндрэлтэй байна.

3.3.4. Өмнөх аудитын шийдвэрүүдээс 2 албан шаардлага бүрэн хэрэгжээгүй, үлдэгдэлтэй байна.

3.3.4.1. Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитаар шалгагдагч байгууллагуудад нийт 5 зөвлөмж өгснөөс тайлант онд шийдвэрийн хэрэгжилт 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн байна.

3.3.4.2. Харин өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар өгсөн аудитын шийдвэрүүдээс үлдэгдэлтэй байгаа буюу хэрэгжээгүй 2 албан шаардлага байна. Үүнд:

- Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн 50 ортой хүүхдийн дотуур байрны барилгыг чанарын доголдлын асуудлыг арилгуулахтай холбоотой өгсөн 2023.04.20-ны өдрийн 193 тоот албан шаардлага,
- Мөнххаан сумын ЭМТ-ийн барилга, Уулбаян сумын Соёлын төвийн барилга, Наран сумын хүүхдийн цэцэрлэгийн барилга зэрэг төсөл арга хэмжээний чанарын доголдлын асуудлаар өгсөн 2024.04.25-ны өдрийн 79 тоот албан шаардлага

3.3.4.3. АЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй дээрх 2 албан шаардлагын хэрэгжилтийн талаар энэхүү аудитын хугацаанд уулзалт хийж, хэлэлцсэн бөгөөд тус хэлтсийн албан хаагч нар эдгээр албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

---000---

Холбогдох байгууллагын санал:

1. Аймгийн ЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсээс тайлангийн төсөлтэй холбоотой санал, тайлбар байхгүй гэдгээ мэдэгдсэн.
- 2.



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

2. 2.1.4.1. Тендер зарласнаас нээх хүртэлх хугацаа 21-29 хоног байгаа нь хуулиар тогтоосон доод хугацааг ерөнхийдөө хангаж байгаа боловч эрх шилжүүлсэн болон үнэлгээний хороо байгуулсан өдрөөс тендер зарлах хүртэл зарим төсөл, арга хэмжээнд хугацаа ихээхэн алдсан байна.
2. 2.1.4.2. Тухайлбал, 2025.01.23-нд эрх шилжсэн зарим арга хэмжээнд тендерийг 2025.04.09-04.23-нд зарласан нь худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулаагүй, бэлтгэл үе шат удааширсныг харуулж байна.

Хариу тайлбар: Эрх шилжүүлж буй газрууд нь шийдвэр гарсны дараа цахим системээр эрх шилжүүлтийг баталгаажуулдаг. Уг баталгаажуулалтыг хийхдээ шийдвэрийн огноог нөхөж оруулах боломжтой бодит огноо ордоггүй учир хугацааны зөрүү гарч байна. Мөн захиалагчаас техникийн тодорхойлолт, зураг төсөв, холбогдох баримт бичгийн бүрдэл хангагдаж ирсэн тухай бүр худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулдаг. Дээрх процессууд нь хугацаа алдах нөхцөл байдал үүсдэг.

Санал: Тайлан дүгнэлтээс хасуулах

Үүнд:

1. 2.1.3.3. Түүнчлэн "Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат" төсөл, арга хэмжээний багц 1 буюу 15 айлын орон сууц худалдан авах /Баруун-Урт сум/, багц 3 буюу 15 айлын орон сууц худалдан авах /Мөнххаан сум/ арга хэмжээг цахим системд зарлахдаа тендер шалгаруулалтын төрлийг "ажил" гэж сонгосон байна. Тухайн арга хэмжээний агуулга нь бэлэн орон сууц худалдан авах шинжтэй тул "бараа"-ны худалдан авалтад хамаарахаар байхад "ажил" гэж буруу ангилсан нь цахим системд нийтэлсэн мэдээлэл, тендерийн баримт бичгийн агуулга, худалдан авах ажиллагааны бодит шинжтэй нийцээгүй байна.

Хариу тайлбар: Монгол улсын хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 24 тоот тушаалаар Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат /Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Онгон, Мөнххаан, Баяндэлгэр, Наран сум/ ХББСОЯ/20250101044 дугаартай ажлын тендерийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах эрх цахим системээр шилжиж ирсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө бараа ажил, үйлчилгээ, худалдан авах тухай (цаашид хууль)-ийн 10 дугаар зүйлийн 10.5 (Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно) дахь заалт захиалагчаас таван багц болж төхнийн тодорхойлолт батлагдсаны дагуу гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан. Тус төсөл арга хэмжээ нь яамны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ажил гэсэн төлөвтэй төлөвлөгдөж эрх шилжиж ирсэн тул тендерийн төрлийг өөрчлөх боломжгүй байдаг.

Санал: Тайлан дүгнэлтээс хасуулах

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ТАЙВАНСАНАА

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

“Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайлангийн төсөлд санал авахаар 2026.04.29-ний өдрийн 282, 283 тоот албан бичгээр аймгийн ЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс болон аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн бөгөөд Худалдан авах ажиллагааны газраас 2026.05.01-ны өдрийн 159 тоот албан бичгээр хариу ирүүлсэн. Ирүүлсэн албан бичигт аудитын зарим дүн, дүгнэлттэй холбоотой санал, тайлбар ирүүлсэн байх тул тайлбарыг аудитын тайланд тусган өөрчлөлт орууллаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. УТХО-ын төсөл, арга хэмжээ нь хөгжлийн бодлогод нийцэж байгаа ч төсөвт өртгийн тооцоолол, ТЭЗҮ-ийн үндэслэл нотолгоонд суурилаагүй, санхүүжилтийн хуваарилалт Төсвийн тухай хуулийн 29.3.5 дахь заалтыг зөрчсөн нь дараагийн жилүүдэд төсвийн ачаалал үүсгэх, төсөл хугацаандаа дуусахгүй байх эрсдэлийг бүрдүүлж байна
2. Худалдан авах ажиллагаа хэлбэрийн хувьд зохион байгуулагдсан боловч батлагдсан төлөвлөгөө, цахим систем, техникийн тодорхойлолт, үнэлгээний баримтжуулалтын зөрчлөөс шалтгаалан хууль ёсны, үр ашигтай, өрсөлдөөнт ажиллагаа бүрэн хангагдсан гэж үзэх боломжгүй байна.
3. Тендерийн баримт бичиг, үнэлгээний шатанд мэргэжлийн шаардлагыг буруу тогтоосон болон шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан нь худалдан авах ажиллагааны “чанарын хяналт”-ын ноцтой сул тал болж байна.
4. Ашиглалтад хүлээн авсан зарим төсөл, арга хэмжээний дутуу болон өөрчлөгдсөн ажлыг бодит хэмжилт, өөрчлөлтийн зураг төсөв, төсвийн баталгаажуулалтаар нотлоогүй нь илүү санхүүжилт, чанарын доголдол, ашиглалтын эрсдэл үүсгэж байна.
5. Хөрөнгө ашиглалтад орсон боловч өмчлөх эрх, үндсэн хөрөнгийн бүртгэл, үр дүнгийн тайлагнал бүрэн хийгдээгүйгээс хөрөнгийн эзэмшил, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх боломж хязгаарлагдаж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

АЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст:

1. Барилга байгууламжийн бетон хийц, өрлөг, заслын ажил бүрийн чанарын хяналтыг бетон сорьцын лабораторийн шинжилгээний дүн, материалын тохирлын гэрчилгээ, материал хүлээн авалтын баримтаар иж бүрэн баталгаажуулж хэвших, гүйцэтгэлийн санхүүжилт олгох тухай бүр захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд болон гүйцэтгэгч нараас техникийн хяналтын баримтыг иж бүрэн гаргуулж авах, ажлын онцлогт тохирсон баримтын бүрдлийг хянах хяналтын хуудас боловсруулж, түүгээр хяналт тавьж ажиллах.
2. Мөнххаан сумын төрийн албан хаагчдын 15 айлын орон сууцны үл хөдлөх хөрөнгийн эрхийн шилжүүлэг хийгдээгүй байхад санхүүжилт олгосон зөрчлийг арилгуулж, өмчлөх эрх шилжүүлсэн баримтыг бүрдүүлэх, цаашид улсын бүртгэлийн гэрчилгээ, өмчлөх эрх шилжүүлсэн лавлагаа, хүлээн авсан

акт зэрэг баримтыг бүрдүүлсний дараа санхүүжилт олгох хяналтын тогтолцоог бий болгох.

3. “Соёл амралтын хүрээлэн багц-1, 2 /Сүхбаатар аймаг, Баруун-Урт/” болон “Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Сүхбаатар, Асгат сум/” төсөл, арга хэмжээний өөрчлөгдсөн болон дутуу гүйцэтгэсэн ажлуудын бодит гүйцэтгэлийг баримтаар баталгаажуулж, ажлын зураг төслийг бодит гүйцэтгэлтэй нийцүүлэн шинэчлэн гаргуулж, өөрчлөлтийн төсвийг эрх бүхий этгээдээр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр гүйцэтгэлийн хяналтыг дахин хэрэгжүүлж, илүү олгосон буюу үндэслэлгүй санхүүжүүлсэн дүн байгаа эсэхийг тооцон холбогдох арга хэмжээ авч ажиллах.
4. Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Сүхбаатар, Асгат сум/, Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Сүхбаатар, Асгат сум/, Соёл амралтын хүрээлэн багц-1,2 /Сүхбаатар аймаг, Баруун-Урт/ зэрэг төсөл, арга хэмжээнүүдийн дутуу хийгдсэн ажлуудыг хийлгэх болон чанарын доголдлыг арилгуулах асуудлаар захиалагч болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд гэрээний ерөнхий нөхцөлд заасны дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах.

Сүхбаатар аймгийн Худалдан авах ажиллагааны газарт:

1. Эрх шилжиж ирсэн болон төсөвт тодотгол, зохицуулалтаар нэмэгдсэн төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнд тухай бүр бүрэн тусган нэмэлт, өөрчлөлт оруулж баталгаажуулах, мөн түүнчлэн батлагдсан төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлсэн мэдээллийн уялдаа, үнэн зөв байдлыг хангаж ажиллахыг зөвлөж байна.
2. Улсын төсвөөр санхүүжих, эрх шилжүүлэн зохион байгуулах төсөл, арга хэмжээний дэлгэрэнгүй захиалга, техникийн тодорхойлолт, холбогдох баримт материалыг “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих” журмын 2.2-т заасны дагуу Худалдан авах ажиллагааны газарт албан бичгээр хүргүүлж хэвших.
3. Тендерийн баримт бичигт заасан шаардлага хангаагүй, эсхүл нотлох баримт дутуу ирүүлсэн оролцогчийг шаардлага хангасан гэж үнэлэхгүй байх, мөн тендерийн баримт бичигт тусгай зөвшөөрлийг барилгын хийц, бүтээцтэй уялдуулан тусгах, түүнчлэн цахим системд худалдан авах ажиллагааны төрлийг үнэн зөв сонгож үнэлгээний хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

---oOo---